

“НУРБАХ” ХХК

Баяннур, Алтанцөгц, Ногооннуур суманд хийгдсэн булгийн хамгаалалтын тайлан

2022 ОН

Булаг шандын эхийг хашиж хамгаалах ажлын тайлан

Үндэслэл:

Баян-Өлгий аймгийн Баяннуур, Алтанцөгц, Ногооннуур сумын нутагт орших олон голуудын эх болсон экологийн онцгой ач холбогдолтой газар юм.

Сүүлийн жилүүдэд мөнх цас, мөсөн голууд хурдтай хайлж нуур цөөрөм, гол горхи, тэр дунда булаг шанд ихээр ширгэж байна. Үүнийг эрдэмтэд тайлбарлахдаа дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлттэй шууд холбон үзэж байна.

Ан амьтаны ус уудаг Ногооннуур сумын Хавцлын булаг, Алтанцөгц сумын Чигтэйн булаг, Баяннуур сумын 3 дугаар баг Долдабайн булагт гэдэг нэртэй газарт булаг шандын усны эх ундарга малын хөл, ялгадасаар ихээхэн бохирдож, зарим газарт ашиглах боломжгүй болж, ундарга нь багсаж татарч ширгэх хандлага ажиглагдах боллоо.

Иймд уг булгийн эх ундаргыг одооноос эхлэн хамгаалж, хүний зүгээс үзүүлж байгаа сөрөг үр дагаваруудыг зогсоох, зүй зохистой, тогтвортой ашиглалтыг бий болгох зорилгоор эхийг хамгаалж тохжуулах зайлшгүй шаардлага гарсан.

Ажлын гүйцэтгэл:

1. Баяннуур, Алтанцөгц, Ногооннуур сумын нутагт орших 3 булгийн эхийг малын хөл, ялгадсаар бохирдох, эх ундарга нь ширгэхээс хамгаалж БОАЖГ-ын баталсан булагийн техникийн тодорхойлолтын дагуу хашаа, хайс барьж тусгаарлав.

2. Самбар босгож тэмдэгжүүлэв.

3. Булгаас ус уухаар ирсэн ард иргэд, зорчигчид тухтай сууж ус уухаар сүүдрэвч, сандал байрлуулав.

4. Орчин тойрноо цэвэр байлгах зорилгоор хогийн сав байрлуулав.

Булаг шандын эхийг хашиж хамгаалсанаар шийдвэрлэсэн асуудал, үр дүн :

Үүнд :

- Ан амьтаны ус уух булаг шандын усны эх ундаргыг малын хөл, ялгадсаар бохирдохоос хамгаалав.
- Бохирдож, зарим газарт ашиглах боломжгүй болж, ундарга нь багасаж татарч ширгэх хандлага ажиглагдсан булгийн ундаргыг ихэсгэв.
- Усны тухай хууль, усны үнэ цээний тухай мэдлэг мэдээллийг түгээх, сурталчилгааны самбар байрлуулсанаар олон нийтийн оролцоог өргөжүүлэв.
- Ард иргэдийн амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх оршин бий болгов.

Ажил гүйцэтгэсэн технологи:

Булгийн эхийг тохижуулахын тулд орчин үеийн дэвшилтэд техник, технологийг уламжлалт арга барилтай хослуулан гүйцэтгэв. Үүнд:

1. Булгийн хөрсний нэвчилтээс гадуурх талбайгаар булаг шандын эхийг хашиж хамгаалах ажлыг гүйцэтгэв.

2. Хамгаалалтын төмөр хийцийн хашааг барихдаа торыг угоник төмрөөр хайрцаглан бэхлэж, бетонон болон төмөр хөлийг барилгын норм ба дүрмийг баримтлан хийв.


3. Бетонон болон төмөр шонгийн урт нь 2 м өндөр, өргөн 5х6 хэмжээтэй байна

4.Булгийг хашигдаа хашааны өндөр 1,5 м шон хоорондын зай 2 м байх бөгөөд шонг газарт 50 см гүнтэйгээр бетондож бэхлэв.

5.Явган хүн орж гарах хаалга,ус булаг шанд рашааны эхийг хайрлан хамгаалах талаар санамж мэдээлэл бүхий самбар байрлуулав.

4.Орчин тойрноо цэвэр байлгах зорилгоор хогийн сав байрлуулав.

Хашиж хамгаалахаас өмнө Ажлын явц




Хашиж хамгаалахаас өмнө

Ажлын явц



Хашиж тохижуулсны дараа







БУЛГИЙН ЭХИЙГ ТОХИЖУУЛСАН ЭДИЙН ЗАСГИЙН ТООЦОО

№	Багажны нэр	Хэмжих нэгж	Тоо, ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ \мян.төг\
1	Төмөр тор	метр	40	10000	400.0
2	Шонгийн турбо 50мм	метр	130	6000	780.0
3	Цемент	ширхэг	2	18000	36.0
4	Гагнуур хийлгэх	метр	65,6	500	131.0
5	Сүүдрэвч хийлгэх	ширхэг	1	150000	150.0
6	Будаг	кг	5	5000	25.0
7	Хаалга хийлгэх төмрөөр	ширхэг	1	100000	100.0
8	Өлгийгөөс самбар төмөр тор шонгийн турбо бусад зүйлсийг тээвэрлэн хүргэх бензин	литр	120	1700	204.0
9	Жолоочийн хөлс	хоног	2	42000	84.000
10	Булаг шандын эхийг хамгаалж тохижуулах	хоног	3 хүн х 2 хоног	15000	90.000
Дүн					2.000.000